

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧТАЙ
БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 14

Улаанбаатар хот

Д/д	Гэрээний заалтын дугаар	Гэрээний заалт	Хэрэгжилт	Хэрэгжилт-ийн хувь
1.	2	3	4	5
3.1.Хууль, дүрэм, энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцна.				
1.	3.2.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилтын хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг 2022 оны нэгдүгээр улиралын тайланг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 2/552, хоёрдугаар улирлын тайланг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 2/1101, гуравдугаар улирлын тайланг 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 2/1607, дөрөвдүгээр улирлын тайланг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр 2/2178 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тус тус хугацаанд нь тайлагнан ажилласан байна. Нийслэлийн хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөний нэгдүгээр улирлын хэрэгжилтийн тайланг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр 2/552, хоёрдугаар улирлын тайланг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 2/1101, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг гуравдугаар улирлын байдлаар 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 2/1572 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст (цаашид НЗДТГ-ын ХШҮХ гэх) тус тус хугацаанд нь тайлагнан ажиллалаа. Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээ 2022 оны зорилтот түвшинд хүрч бүрэн хэрэгжсэн.	100%
2.	3.3.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөөг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн Худалдан	100%

		сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.	<p>авах ажиллагааны газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Нийт албан хаагчдын хурлаар 2 удаа хэрэгжилтийг тайлагнасан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/656 дугаар захирамжийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн Б/60 дугаар тушаалаар орлогч даргыг албан тушаалаас чөлөөлж 11,7 сая төгрөг хэмнэж, Нийслэлийн төр захиргааны автобааз УТҮГ-тай 2022 оны нэгдүгээр сард байгуулсан гэрээг цуцалж, байгууллагын албан хэрэгцээнд дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээг байгуулж, тээврийн зардалд хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн, бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэж ажилласнаар 23 хувиар буюу 3,0 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Албан бичгийн хариуг цахим хэлбэрээр байгууллага, иргэдэд хүргүүлж шуудангийн зардлыг хэмнэсэн 150,0 мянган төгрөг, интернэтийн урсгал зардлыг гэрээний үнийг бууруулж гэрээ байгуулснаар 1,6 сая төгрөг, тендерийн урилга хэвлүүлэх зардал төлөвлөсөн болон зах зээлийн үнээс 35 хувь бага үнээр гэрээ байгуулж 10,5 сая төгрөг хэмнэсэн. Мөн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (2022 онд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдэх ажлуудыг)-г олон нийтэд мэдээлэх, зар хүргэх ажлын хүрээнд QR код ашиглан 6 нүүрт хэвлэгдэх 6,0 сая төгрөгөөр хэвлэх зарыг 0,24 сая төгрөгөөр хэвлүүлж 5,76 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Нийт 32,71 сая төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан байна.</p>	
3.	3.4.	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14, 15, 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ыг баримтлан гүйцэтгэх 12 албан тушаал, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”-ыг баримтлан чадахуйн зарчмыг үндэслэн удирдах 2, гүйцэтгэх 5 албан тушаалын сул орон тоог тус тус нөхөж ажилласан.	100%
4.	3.5.	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх	-Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (2022 онд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдэх ажлуудыг)-г олон нийтэд мэдээлэх, зар хүргэх ажлын хүрээнд QR код ашиглан 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн	

	<p>нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.</p>	<p>“Зууны мэдээ сонин”-д хэвлүүлж, байгууллагын вэб сайт (www.ub-procurement.mn)-ын Үйлчилгээ-Худалдан авах ажиллагаа-Төлөвлөгөө цэсэд мөн Нийслэлийн www.ulaanbaatar.mn веб сайт, “Нийслэлийн мэдээ” фэйсбүүк хуудаст байршуулан олон нийтэд нээлттэй хүргэсэн.</p> <p>-Байгууллагын цахим хуудас www.ub-procurement.mn мөн байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар Худалдан авах ажиллагааны хууль, журмын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 23 мэдээ мэдээллийг байршуулан иргэд, аж ахуйн нэгж, тендерт оролцогч сонирхогчдыг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>-ХАА-ны чиглэлээр НЗДТГ, Нийслэлийн нутгийн захиргааны 4 байгууллага (НХТГ, ННХГ, НОСБГ, БГДЗДТГ) болон тус газрын ТХААХ-ийн албан хаагчдад “ТБОНӨХБАҮХАТХ”, “Тендерийн баримт бичиг боловсруулах, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаал”-ын талаар мэдлэг олгох 6 сургалт зохион байгуулж, нийт 83 албан хаагч хамрагдлаа.</p> <p>-Нийслэлийн 9 дүүргийн нийт 41 жижиг, дунд эрхлэгчид болон ЖДҮ дэмжих төвийн мэргэжилтнүүдэд Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих төв НӨҮГ-тай хамтран ТБОНӨХБАҮХАТХ-ийн мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.</p> <p>-Сангийн яам, ТХААГ, АТГ, ШӨХТГ хамтран Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаарх сургалт, уулзалтыг 2022 оны 09 сарын 05-ны өдөр Нийслэлийн Засаг захиргааны тавдугаар байр, Иргэний танхимд зохион байгуулж ажилласан. Тус сургалтад Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 10 агентлаг, орон нутгийн өмчит 19 байгууллага, дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын нийт 180 гаруй албан хаагчийг хамруулсан.</p> <p>-ТХАА-ны www.tender.gov.mn цахим систем ашиглалтын талаар Яам, ННЗБ, дүүргүүдийн ХАА-ны алба, орон нутгийн өмчит аж, ахуйн тооцоот үйлдвэрийн газар зэрэг 53 байгууллагын албан хаагчдад 426 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>-Тус газарт зохион байгуулагдаж буй 328 төсөл, арга хэмжээний нээлтийг “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар” фэйсбүүк хуудсаар шууд дамжуулан ажилласан. Мөн 376 төсөл, арга хэмжээний урилгыг “Зууны мэдээ сонин”-д хэвлүүлсэн.</p> <p>-Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагааны тайлан мэдээний цахим системд (www.report.ub-</p>	
--	--	--	--

			procurement.mn) худалдан авах ажиллагаа зохион байгуулж байгаа 39 байгууллага төсөл, арга хэмжээний явцын мэдээллийг тухай бүр бүртгэн ажиллаж байна. Тус газраас системд оруулсан мэдээлэлд боловсруулалт хийж, НЗДТГ-ийн 2022 онд нэвтрүүлсэн Дашбаордод байршуулж, төсөл, арга хэмжээний явцыг олон нийтэд ил тод байдлыг ханган ажилласан.	
5.	3.6.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 9 зүйл, 23 заалттайгаар 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлуулсан. УА, НЗДТГ Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан 36 төрлийн 55 удаагийн сургалтад давхардсан тоогоор 217 албан хаагчийг хамруулсан. Нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх чиглэлээр 15 албан хаагчид тусламж, дэмжлэг үзүүлсэн. 2021 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн 8 албан хаагчийн цалингийн шатлалыг, 11 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан болон шинээр олгуулсан. Газарт үүссэн удирдах албан тушаалын 5, гүйцэтгэх албан тушаалын 11 сул орон тооны мэдээлэл болон тусгай шалгалт зарлуулах захиалгыг 2022 оны 2/44, 2/354, 2/1385 дугаар албан бичгээр ТА3-ийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлснээр удирдах албан тушаалын 3, гүйцэтгэх албан тушаалын 14 сул орон тоог нөхсөн. Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол гүйцэтгүүлж, ажиллах нөхцөл, таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч ажилласан. Хуульчдын өдрийг тохиолдуулан хуульч, эрх зүйч мэргэжилтэй 7 албан хаагчийг шагнуулахаар холбогдох материалыг НЗДТГ-ын хүргүүлснээр 1 албан хаагч салбарын “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 1 албан хаагч “Жуух” бичгээр шагнуулсан. Төрийн албан хаагчийн тэргүүний ажилтан цол тэмдгээр 1 албан хаагч шагнуулсан. Монгол Улсад Худалдан авах ажиллагааны салбарын 10 жил тохиож байгаатай холбогдуулан Төрийн одон медалиар 6, Сангийн яамын шагналаар 4, Хууль, дотоод хэргийн яамны шагналаар 2, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны шагналаар 1, ТА3-ийн шагналаар 1, Нийслэлийн шагналаар 10, МЗХ-ны шагналаар 2 албан хаагчийг шагнуулахаар тодорхойлж, холбогдох материалыг хүргүүлсэн. 2022 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу гарган НЗДТГ-т 2/1175 дугаар албан бичгээр хүргүүлэн, цахим хуудаст байршуулсан. Жилийн эцсийн биелэлтийг 12 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэхээр төлөвлөж	100%

			байна.	
6.	3.7.	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.	Байгууллагын цахим хуудаст “Ил тод байдал” цэсний “Үйл ажиллагааны ил тод байдал” хэсгийн “Өргөдөл гомдлын шийдвэрлэлт”-хэсэгт улирал бүр өргөдөл, гомдлын тайланг байршуулж хэвшсэн. 2022 оны өргөдөл, гомдлын эхний хагас жилийн тайланг 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2/1248 дугаар албан бичиг, 2022 оны гуравдугаар улирлын тайланг 2022 оны 09 дүгээр сарын 30–ны өдрийн 2/1768 дугаар албан бичгээр тус тус Нийслэлийн Нэгдсэн үйлчилгээний төвд илгээж, газрын цахим хуудаст байршуулан ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 100 хувьтай байна. Жилийн эцсийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 30 –ны өдөр тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна.	100%
7.	3.8.	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.	Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн 25 удаа хуралдаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас тус газрын чиг үүрэгт хамааралтай 132 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж, 28 удаа тайлагнасан. 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 132 үүрэг даалгаврын дундаж хэрэгжилт 92 хувийн (системд тайлагнах үеийн хэрэгжилт) гүйцэтгэлтэй байна.	100%
8.	3.9.	Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан “Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх чиг үүрэг”-ийн хүрээнд 2 зорилтын 5 арга хэмжээ, “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” хүрээнд 6 зорилтын 7 арга хэмжээ, “Хуулиар олгосон чиг үүрэг”-ийн хүрээнд 9 зорилтын 12 арга хэмжээ, “Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг”-ийн хүрээнд 14 зорилтын 17 арга хэмжээ, нийт 31 зорилтын 41 арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган ажиллаж, хагас, бүтэн жилээр 2 удаа хугацаанд нь тайлагнан ажилласан. Хагас жилийн гүйцэтгэлийн тайлан 80,2 хувийн гүйцэтгэлтэй байсан бол жилийн эцсийн тайлангийн хэрэгжилт 98,7 хувийн гүйцэтгэлтэй байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр НЗДТГ-т 2/1302 тоот албан бичгээр хүргүүлсэн. Бүтэн жилийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн албан бичгээр тайлагнасан.	100%

9.	3.10.	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор ublegal.ulaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.</p>	<p>2021 оны жилийн эцсийн байдлаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэх хөтлөх журам”-ын хэрэгжилтийг хангаж, мэдээг 2022.01.03-ны өдрийн 4/11, 2022 оны I улирлын байдлаар 2022.04.01-ний өдрийн 4/479, 2022 оны II улирлын байдлаар 2022.07.05-ны өдрийн 4/1305, 2022 оны III улирлын байдлаар 2022.10.05-ны өдрийн 4/1809 дүгээр албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т тус тус 4 удаа хүргүүлсэн.</p> <p>Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан (ublegal.ulaanbaatar.mn) 2022 оны 02 дугаар сараас эхлэн хэвийн ажиллаж эхэлсэн бөгөөд</p> <ul style="list-style-type: none"> ✓ 2019 оны А тушаал 71-166; ✓ 2020 оны А тушаал 1-105, Б тушаал 1-105; ✓ 2021 оны А тушаал 1-151, Б тушаал 1-88; ✓ 2022 оны А тушаал 1-114, Б тушаал 1-123; <p>2019-2022 оны нийт А тушаал 465, Б тушаал 316 тушаалыг нөхөж оруулан ажиллаж, олон нийтийг танилцах боломжоор хангасан.</p>	100%
10.	3.11.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.</p>	<p>Шилэн дансны системд байршуулах санхүүгийн мэдээллийг хугацааны хоцрогдолгүй, бүрэн гүйцэд мэдээлж, шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Байгууллагын төсөв, санхүүгийн холбогдолтой жил, улирал, сарын хугацаанд байршуулах 17 төрлийн 95 мэдээллийг олон нийтэд мэдээлсэн. Үүнд: төсөв гүйцэтгэлтэй холбоотой 43, хөрөнгө оруулалт, тендер худалдан авах ажиллагаатай холбоотой 12, бусад төрлийн санхүүгийн холбогдолтой 40 мэдээлэл шилэн дансанд мэдээлсэн байна.</p> <p>Аудитын байгууллагаас худалдан авах ажиллагаатай холбоотой 1, концесс, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт 1, албан шаардлага 2, зөвлөмж, түүний хэрэгжилтийн 1 мэдээллийг шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>-Шилэн дансны системд байгууллагын хүний нөөц, бүтэц орон тоотой холбоотой мэдээллийг 12 удаа нийтэлсэн.</p> <p>Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нараас 195 ширхэг “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг хянан хүлээн авч Шилэн дансны системд мэдээлж ажилласан.</p> <p>-Гэрээ байгуулагдсан 178 төсөл, арга хэмжээний холбогдох мэдээллийг маягтын дагуу хуулийн хугацаанд багтаан Шилэн дансны системд мэдээлж ажилласан.</p> <p>-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд</p>	100%

			<p>заасан мэдээллийн байгууллагын цахим хуудаст 4 чиглэлээр 13 төрлийн мэдээллийг нийтэлсэн.</p> <p>Жилийн эцсийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар байгууллагын цахим хуудаст байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод нээлттэй байдал”-ыг тайлагнах хүснэгтээр хагас, бүтэн жилээр 2 удаа НЗДТГ-т тайлагнасан.</p>	
11.	3.12.	<p>1.Хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох” тухай 62 дугаар тогтоол,</p> <p>2.2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоол,</p> <p>3.2020 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" батлах тухай 218 дугаар тогтоол,</p> <p>4.2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол,</p>	<p>1.Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/779 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Сайжруулсан түлш болон дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 15 тушаалын дагуу тус газрын 25 албан хаагч хуваарийн дагуу СХД-ийн 23, 39 дүгээр хорооны Засаг даргын ажлын алба (өрхийн эрүүл мэндийн төв)-тай хамтран 2022 оны 01-03 сарыг дуустал хяналтаар ажиллаж, угаарын хий хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг иргэдэд өгч, түүхий нүүрс айл өрх, түлсэн эсэхэд хяналт тавьж ажилласан. 14 удаагийн мэдээг тогтсон хугацаанд нь хүснэгтээр НЗДТГ-ын “Түлшний хяналт-3” вайбер бүлгээр дамжуулан тайлагнаж ажилласан. 8 түлшний цэгт хяналт тавин ажиллаж, 2 хорооны 2990 иргэн дархлаажуулалтын нэмэлт тунд хамрагдсан талаарх мэдээллийг өгч ажиллалаа.</p> <p>2.2022 оны Засгийн газрын 217 дугаар тогтоолын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 31 зорилт, 41 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, 2022 оны 01 дүгээр сард Төсвийн Ерөнхийлөн захирагчаар батлуулсан.</p> <p>3.2022 оны Засгийн газрын 218 дугаар тогтоолын дагуу 2022 оны 01 дүгээр сард 29 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн дарга байгуулсан. Гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт тавих үнэлгээний багийг Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар байгуулсан. Үнэлгээний баг дээрх журмын дагуу 2022 оны хагас, бүтэн жилээр ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын дагуу өдөр үнэлгээний баг баталгаажуулсан бөгөөд газрын даргад танилцуулан үнэлгээний дагуу арга хэмжээ авахаар ажиллаж байна.</p> <p>4.2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний</p>	

			тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд 2022 оны 06 дугаар сард хяналтаас хасагдсан.	
		<p>5.2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоол,</p> <p>6.2021 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах” тухай 360 дугаар тогтоол,</p> <p>7.2020 оны “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 206 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>5.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан НХААГ-ын даргаар батлуулж, хэрэгжилтийн ханган ажиллаж байна.</p> <p>-2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>-“Удирдлагын зөвлөл”-ийн өргөтгөсөн хурлаар Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар албан хаагчдад мэдээлэл өгсөн. Тус хурлын үеэр албан хаагчдаас гарсан саналын дагуу шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг гаргаж, НЗДТГ-ын Санхүү Төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. 2022 онд нийт 32,71 сая төгрөгийн төсвийн хэмнэлттэй ажилласан.</p> <p>6.Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг баталсны дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1128 дугаар захирамж гарч тус газар нь 40 хүртэл албан хаагч, 4 хэлтэстэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>7.2022 оны Засгийн газрын 2020 оны тогтоолын дагуу “Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын 2022 оны төлөвлөгөө”-нд 3 зорилтын 14 арга хэмжээг тусган 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөө 100 хувь хэрэгжиж, 19 удаа хяналт-шинжилгээ хийж, нийслэлийн шуурхай болон байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд тухай бүр үнэлгээ өгч ажилласан.</p>	